

Батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэл: Үндэсний ухамсар ба либерал-ардчилсан үнэт зүйлсийн зөрчилдөөн

Тэрбишийн Билгүүн

Магистр, эрдэм шинжилгээний ажилтан, bilguun@mids.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн

Хураангуй

Энэхүү өгүүлэл нь Монголын нийгэмд түгээн дэлгэрч буй прогрессив либерал дискурсын нөлөөг авч үзсэн бөгөөд үндэсний ижилсэл, хамтын ухамсар, уламжлалт үнэт зүйлсэд учруулж буй сорилтыг тодорхойлох зорилготой.

Тус өгүүлэлд социологийн сонгодог ба орчин үеийн онолууд, улс төрийн реализмын шүүмжлэлийг хослуулан ашигласан бөгөөд ялангуяа Дюркгеймийн хамтын ухамсар, Фукургийн дискурс, Бурдьегийн символик эрх мэдэл, Бузаны нийгмийн аюулгүй байдлын онолын ойлголтуудыг тулгуур болгон ашигласан. Арга зүйн хувьд Норман Фэйрклофийн шүүмжлэлт дискурс шинжилгээнд тулгуурлан Монголын залуучууд руу чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг иргэний нийгмийн байгууллагуудын нийтэд нээлттэй баримт бичиг, цахим эх сурвалж болон ярилцлагын өгөгдлийг хамруулсан. Шинжилгээний хүрээнд нийгмийн эв нэгдэл, соёлын залгамж чанарын ач холбогдол, аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлогод үүсэж буй асуудлыг дурдсан бөгөөд прогрессив либерализмын үнэт зүйлсийг нутагшуулах оролдлого нь уламжлалт үнэт зүйлстэй үндсээрээ зөрчилдөж, нийгмийн итгэлцэл, хамтын ухамсар, үндэсний үзлийн дархлааг алгуур сулруулж буй эсэхийг тодруулав.

Түлхүүр үг: Үндэсний ижилсэл, хамтын ухамсар, батлан хамгаалах бодлого, либерал-прогрессивизм, символик эрх мэдэл

Оршил

Өнөө үед эрх чөлөө, хүний эрх, ардчиллын суурь зарчмууд нь дэлхий нийтийн нийгэм-улс төрийн тулгуур үнэт зүйлсийн нэг болж, хүлээн зөвшөөрөгдсөн хэдий ч тэдгээрийн агуулга, хөгжлийн хэлбэр нь улс бүрийн түүхэн замнал, соёлын онцлог, улс төрийн философи үзэл баримтлалаас хамааран харилцан адилгүй байдаг. Хүний эрх, ардчилал зэрэг либерал үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлдэг барууны олон улсын байгууллага, донор орнууд эдгээр үнэт зүйлсийг нийтлэг хэм хэмжээ хэмээн зарлаж, хөгжлийн шалгуур болгон дэлхий даяар түгээхдээ тухайн орны нийгэм-соёлын онцлогийг үл тоомсорлох нь элбэг.

Монгол Улсын хувьд либерал-ардчилсан үзэл санааны нөлөө нь зөвхөн улс төрийн тогтолцоонд төдийгүй иргэдийн ёс суртахууны баримжаа, хамтын ухамсар,

үндэсний ижилсэлд гүн нөлөө үзүүлж эхэлжээ. Энэ нөлөө нь үндэсний аюулгүй байдал, тэр дундаа Барри Бузаны тодорхойлсон нийгмийн аюулгүй байдлын хэмжээсээр авч үзвэл, соёлын залгамж чанар болон нэгдмэл, тогтвортой байдалд стратегийн сорилт үүсгэж байна (Buzan, Wæver, & De Wilde, 1998)

“Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн тавдугаар бүлгийн 5.1-д “*Монгол Улсын хүний хөгжил нь батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлийн үндэс мөн*” хэмээн заасан байдаг (Монгол Улсын Их Хурал, 2022). Уг баримт бичгийн 2.2-д болон 2.3-д Батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд болон иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаанд суурилахыг тодорхойлсон байдаг (Монгол Улсын Их Хурал, 2022). Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 8.2.5-д *уламжлалт бус аюулаас хамгаалах*; 8.2.6-д *иргэнд эх оронч хүмүүжил төлөвшүүлэх*; 8.2.7-д *иргэний эрүүл мэнд боловсролыг дэмжих* хэмээн заасан нь батлан хамгаалах бодлого зөвхөн зэвсэгт хүчний бэлэн байдлаар хязгаарлагдахгүй, харин иргэдийн ухамсар, соёл, оюун санааны асуудалтай нягт холбоотойг харуулж байна (Монгол Улсын Их Хурал, 2022). Гэвч төр, захиргааны болон иргэний байгууллагууд аливаа аюул заналын өмнө бэлэн байдал нь хэр хангагдсан бэ? Монголчуудын эх оронч ухамсар, хамтын эв нэгдэл, итгэлцлийн түвшин ямар байгаа вэ? гэсэн асуултыг тавих нь зайлшгүй шаардлагатай. Эдгээр асуултад хариулт өгөхийн тулд Монголын нийгмийн өөрчлөлт, ялангуяа соёл, үнэт зүйлстэй холбоотой нийгмийн хувьслыг харгалзан үзэх, түүнийг дагасан нийгэмд шинээр гарч буй, тулгамдаж буй асуудлуудыг анхааралдаа авах нь чухал шаардлагатай.

Монгол Улс нь улс төрийн хувьд олон ургалч болсноос хойш нийгэм, оюун санаанд олон янзын үзэл суртал, шашны урсгалууд хүчтэй нөлөөлсөн ч “хүний эрх, ардчиллыг хамгаалах” нэрийн дор түгсэн шинэ үнэт зүйлс ба тэдгээрийг дагасан иргэний хөдөлгөөнүүд зонхилох хандлагатай байна. Эдгээр үнэт зүйлс нь ихэвчлэн “тэгш эрх”, “жендерийн эрх”, “бэлгийн цөөнхийн эрх” болон “олон соёлт байдал” зэрэг ойлголт, нэр томъёог голчлон хэрэглэдэг. Ийм жишиг нь барууны орнуудад нийгмийн гол ёс суртахуун, үнэт зүйлийн баримжаа болсон байдаг. Зарим тохиолдолд энэ хандлагыг “Leftism,” “Wokism” эсвэл “Соёлын марксизм” ч гэж нэрлэх тохиолдол бий.

Эдгээр шинэ үнэт зүйлс нь Монголын нийгэмд түгээмэл ажиглагдах болсон. Тухайлбал: Гадаадын санхүүжилттэй иргэний нийгмийн байгууллагууд болон зарим улсын Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр залуучуудыг гол зорилтот бүлэг болгодог нийтлэг хандлага байна. Үүний үр дүнд Монголын нийгмийн уламжлалт үнэт зүйлс, эрх мэдлийн тогтолцоо, нийгмийн харилцаа, соёлын үнэт зүйлстэй зөрчилдөх байдал ажиглагдах болсон.

Энэ үйл явц нь нийгмийн дотоод зөрчлийг нэмэгдүүлж, нийгмийн итгэлцлийг сулруулахын зэрэгцээ үндэстний нэгдмэл байдлыг дэмжиж байдаг уламжлалт хэм

хэмжээ алдагдах эрсдэлийг дагуулж байна. Энэхүү судалгаа нь Монголын залуучууд руу чиглэсэн төрийн бус байгууллагууд хэрхэн үзэл суртлын дискурс бүтээж, үндэсний ижилсэл, ялгарлын төлөвшилд ямар нөлөө үзүүлж буйг тодорхойлохыг зорилоо. Ингэснээр Монгол Улсын батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлд тулгарч буй шинэ сорилтыг илрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Нэг. Прогрессив либерализм нь Монголын нийгмийн “шинэ” үнэт зүйл болох нь

Монголын нийгэмд сүүлийн 20 гаруй жил глобалчлалын нөлөөгөөр гадаадын соёл, сэтгэлгээний хэв маяг эрчимтэй нутагшиж “гадаадынх л бол зөв, сайн” гэх туйлширсан байр суурьтай болсон. Энэ хугацаанд “өөрсдийн, үндэсний” гэх аливаа зүйлсийг “хоцрогдсон” гэж үгүйсгэх сэтгэлгээ газар авч, аливаа улс төрийн, соёлын нөлөөллийг шүүлтүүргүй хүлээн авах нөхцөл бүрдсэн. Түүнчлэн Монголын залуу үеийнхэн дунд ахмад үеэ ад шоо үзэх “үеэ өнгөрөөсөн” гэх ангилалд оруулах зэрэг нь эцэстээ нийгмийн үе хоорондын зөрчилд хүртэл хүргэсэн байдаг. Ер нь товчхон дурдахад Монголын нийгэмд дараах хэд хэдэн гол зөрчилтэй асуудал байна. Үүнд: хот-хөдөө; ахмад-залуу үе; эрэгтэй-эмэгтэй; бусад хүйс; чинээлэг-ядуу бүлгийн гэх мэт. Нийгмийн энэ үзэгдэл нь нийгэм-соёлын хурдацтай өөрчлөлтийн тод илрэл мөн бөгөөд соёлын залгамж чанар, оюун санааны нэгдмэл байдал алдагдсаны хор уршиг юм. Энэхүү нийгэм-соёлын задралын цаана түлхэц үзүүлж буй гол үзэл суртлын нөлөө байгаа нь “прогрессив либерализм” юм. Энэ нь зүгээр ч нэг улс төрийн эрхийн тухай үзэл санаа бус нийгмийн институтууд, уламжлалт үнэт зүйлс, эрх мэдлийн зохистой, тэнцвэрт харилцааг “тэгш эрх,” “хүний эрх,” “хүртээмжтэй байдал” болон “жендер” гэх мэт идеологийн ойлголтоор задлах, өөрчлөх зорилготой системчилсэн үзэл суртлын тогтолцоо юм.

Улс төр, олон улсын харилцааны реалист онолын нэрт төлөөлөгч Жон Миршаймер 2018 онд туурвисан “*The Great Delusion: Liberal dreams and International Realities*” бүтээлд АНУ-ын дангаар ноёрхол болон либерализмын бүтэлгүйтэл, либерализмын хувьсал, өнөөгийн байдал, улс орнуудын үндэсний үзлийн сэргэлт зэрэг ач холбогдолтой санаа, баримтыг дурдсан байдаг (Mearsheimer, 2018). Тэрээр прогрессив либерализмыг гэнэн, улс төрийн хувьд тогтворгүй, дэлхийн энх тайван, дэг журмыг алдагдуулах аюултай хандлага хэмээн шүүмжилсэн. Түүний үзэж буйгаар либерал үнэт зүйлсийг дэлхий нийтэд тулган хүлээлгэх оролдлого нь аливаа орны үндэсний үзэл, тусгаар тогтнолын асуудалтай зайлшгүй зөрчилдөж, улмаар эмх замбараагүй байдал, эсэргүүцэл, дайн дажин дагуулдаг хэмээн дүгнэжээ (Mearsheimer, 2018).

Миршаймер нь либерализмыг *modus vivendi* либерализм, прогрессив либерализм гэж хоёр ангилсан байдаг. Товчхондоо энэ хоёр төрлийн либерализм нь хүний мөн чанар, индивидуализм, хүмүүний жам ёсны эрх, олон нийтийн хэв журмыг зохицуулах төрийн үүрэг зэрэг дээр нэгдмэл байр суурьтай байдаг боловч гол ялгарах шинж байдал нь хүний эрх болон төрийн оролцооны тухай сургаалаар эрс ялгардаг.

Жишээлбэл: *modus vivendi* либерализм нь “хувь хүний эрх” гэдгийг хувь хүний эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх, өмчтэй байх эрх гэх мэт төрийн хязгаарлагдмал оролцооны хүрээнд тодотгон багтаадаг. Харин прогрессив либерализм нь мөн адил хувь хүний эрх чөлөөг дээдэлдэг ч гэлээ *modus vivendi* либерализмаас ялгарах гол шинж бол төр нь иргэдийнхээ эрх, тэгш боломжийг хангагч, идэвхтэй оролцогч байх ёстой гэж үздэгт оршино. Иймээс прогрессивистууд тэгш байдал, “нийгмийн шударга ёсны зарчим”-ыг биелүүлэхийн тулд төрөөс нийгмийн инженерчлэл хийх шаардлагатай хэмээн үздэг байна (Mearsheimer, 2018). Үүний улмаас прогрессивистуудын үзэл баримтлал нь зөвхөн эрх тэгш байдлыг тогтооход бус харин ч нийгмийн уламжлалт бүтэц, харилцааг задлан өөрчлөхийн эрмэлздэг. Өөрөөр хэлбэл: тэрхүү “либерал мөрөөдөл”-д хүрэхийн тулд нийгмийг үндсээр нь инженерчлэх хэрэгтэй болдог. Энэ инженерчлэл нь монголчуудын нийгмийн түүхэн туршлага, уламжлалт үнэт зүйлс, үндэсний хамтын ухамсрын эсрэг чиглэсэн байх юм.

Түүхч Гордон Хакийн дурдсанаар “Прогрессив либералистууд нь ихэвчлэн тэдний үзлээс эсрэг байр суурьтай үзлээр өөрсдийгөө тодорхойлдог. Тухайлбал: Цаг уурын өөрчлөлтийг үгүйсгэгчид, үр хөндөлтийн эсрэг үзэлтнүүд, арьс өнгөөр ялгаварлагчид, цагаан арьст үндсэрхэг үзэлтнүүд, жендерийн тэгш байдлыг үл тоомсорлогчид, ёс зүйгүй корпорацууд, феминизм болон ЛГБТК+ эрхийг эсэргүүцэгчид зэрэг багтана” гэжээ (Нак, 2021). Энэхүү үзэл суртал нь барууны орнуудын боловсролын тогтолцоо, улс төрийн институт, олон улсын байгууллагуудын дэмжлэгээр дамжин дэлгэрч, либерал ноёрхлын хүрээнд глобалист үнэлэмжийг түгээдэг. Үүний улмаас үндэсний онцлог, уламжлалт үнэт зүйлс хоёрдогч байр суурьтай болдог. Монголын нийгэмд ч мөн адил элдэв хандив, туслалцааны цаана боловсролын тогтолцоо, сургалтын төлөвлөгөө, иргэний нийгмийн орон зайд хүртэл прогрессивист либерализм нь гүн шингэсэн байдаг бөгөөд энэ нь ард иргэдийн ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйлс, ёс суртахууны чиг баримжаа, цөөн үгээр бол нийгмийн бодит байдлыг өөрчилдөг.

Орчин үеийн Монголын нийгэмд гарч буй соёл, сэтгэлгээний зөрчил, уламжлал ба шинэчлэл, үе хоорондын үл ойлголцол, жендер болон хүний эрхийн үзэл баримтлалтай холбоотой хуваагдал нь зөвхөн нийгмийн өөрчлөлтийн гаднах илрэл төдийгүй илүү гүнзгий нарийн төвөгтэй социологийн утга бүхий мэдлэг, эрх мэдэл, үнэт зүйлийн зохион байгуулалттай холбоотой өөрчлөлт гэдгийг анхаарах нь зүйтэй. Энэ үзэгдлийг тайлбарлахад социологийн шинжлэх ухааны нөлөө бүхий судлаачдын онол, судалгаа үлэмж тус дэм болдог.

Питер Бергер, Томас Лукман нарын “*Social Construction of Reality: A Treatise in Sociology of Knowledge*” гэх бүтээл нь нийгмийн бодит байдал хэрхэн хэл, туршлага, соёлын залгамжаар бүтээгдэж, үе хооронд дамжин тогтдог хийсвэр боловч тогтвортой бүтэц болохыг онцлон тайлбарласан байдаг (Berger & Luckmann, 1966).

Феноменологи философийн хандлагыг ашиглан хүний өдөр тутмын амьдралыг хэрхэн байнгын өөрчлөлтөд байдаг нарийн төвөгтэй үйл явц болохыг тайлбарлахын

зэрэгцээ нийгмийн институцууд хэрхэн бий болдог, бэхжин хадгалагддаг тухай цогц онолыг боловсруулсан байдаг (Parton, 2008, pp. 823). Тэд нийгмийн бодит байдлын тухай тайлбарлахдаа гурван шатлалт үйл явцаар задалсан. Үүнд:

1. *Экстернализация буюу хэлбэржүүлэх.* Хүмүүс өөрсдийн дотоод туршлага, ухамсрыг гадагш чиглүүлэн үйлдэл, хэл, бэлгэдэл, харилцаагаар дамжуулан соёлын бүтээгдэхүүн бүтээдэг. Энэ нь нийгмийн бодит байдал бүрэлдэх эхний үйл явц.
2. *Объективчлэх буюу биежүүлэх.* Хүмүүсийн соёлын бүтээгдэхүүн цаг хугацаа, үе солигдох хооронд харьцангуй тогтвортой, бие даасан, хүнээс хамааралгүй мэт “объектив” бодит байдал болж хувирна. Үр дүнд нь нийгмийн институт, дүрэм журам, уламжлал гэх мэт бүтцүүд үүсдэг.
3. *Интернализаци буюу өөриймшүүлэх.* Хувь хүн тухайн нийгмийн хэл, соёл, бэлгэдэл, үнэт зүйлсийг сурч, нийгэмших үйл явц бөгөөд нийгмийн бодит байдал нь тухайн хүний ухамсарт “өөрийн” болж, бодит мэт ойлгогдох үйл явц.

Бергер болон Лукманы онолоор нийгэм нь механизм, организм гэхээсээ илүүтэйгээр утга учир, оюун санаа, хэлнээс бүрдэх бэлгэ тэмдгийн конструкц гэж тайлбарласан байдаг (Parton, 2008). Энэ тайлбар нь үндэстэн бүр өөрийн онцлог үнэт зүйл, хэл соёл, итгэл үнэмшлээр дамжуулан нийгмийн бодит байдлыг бүтээдэг гэсэн санааг бататгаж өгдөг. Эдгээр санаа нь Францын орчин үеийн нөлөө бүхий сэтгэгчид болох Мишел Фуко болон Пьер Бурдьогийн онолын зарим гол ойлголттой нягт уялдана. Фуко нь мэдлэг болон эрх мэдлийн харилцан хамаарлыг онолын түвшинд гүнзгийрүүлэн судалсан бөгөөд түүний “дискурс” гэх ойлголт нь түүний онолын төвд байдаг. Дискурс гэдгийг мэдлэг, хэл, нийгмийн практикийг бүтээж байдаг сэтгэлгээний тогтолцоо гэж тодорхойлсон байдаг ба энэ нийгмийн бодит байдлыг бүтээж байдаг (Foucault, 1972).

Дискурс нь нийгэмд юу хэлж болох, хэн хэлж, ярьж болох, нийгэмд ямар асуудал “үнэн” гэж хүлээн зөвшөөрөгдөх тухай зохицуулж байдаг эрх мэдэлтэй шууд холбоотой. Нийгмийн хэм хэмжээ, институт болон аливаа бүлгийн ялгарал, тогтцод шууд нөлөөлнө. Жишээлбэл: “Ардчилал бол хамгийн шилдэг засаглалын хэлбэр” гэх ойлголт нь барууны орнуудын боловсрол, улс төрийн институт, олон улсын байгууллагуудаар дамжин түгсэн бөгөөд эдгээрийн дэмжлэгтэйгээр дэлхийн улс орнуудад нийтлэг үнэлэмж болон тогтсон. Энэ нь өөр төрлийн засаглалын хэлбэрийг шууд үгүйсгэх сэтгэлгээний нөхцөлийг бүрдүүлдэг юм. Нөгөө талаас Пьер Бурдьогийн “символик хүчирхийлэл” гэх ойлголт нь ноёрхогч бүлгийн үнэт зүйлс, мэдлэг, соёлын хэм хэмжээг нийгмийн “нийтлэг үнэн” болгон тогтоох үйл явцыг тайлбарладаг ойлголт юм (Bourdieu, 1991, pp. 164-168) Энэхүү хүчирхийлэл нь бие махбодын хүч хэрэглэх бус хүмүүс тухайн тогтолцоог субъектив байдлаараа хүлээн зөвшөөрөх, өөриймшүүлэх замаар хэрэгждэг бөгөөд боловсрол, хэл, хэвлэл мэдээлэл, соёлын үнэлэмж зэргээр дамжуулан ноёрхогч бүлгийн эрх мэдлийг хадгалдаг.

Дээрх онолуудыг Монголын нөхцөлд авч үзвэл “шинэ” либерал үзэл суртал, хүний эрхийн ойлголтууд, тэдгээрийг дагасан бусад жендерийн дискурс нь гадаад, дотоодын санхүүжилттэй байгууллагуудаар дамжин Монголын залуу үеийн оюун санаанд хүчтэй нөлөөлж байна гэж үзэж болно. Энэ хүрээнд ялгаатай байр суурь илэрхийлэгчдийг “*homophobic*” (ижил хүйстнийг эсэргүүцэгч), “*misogynist*” (эмэгтэйчүүдийг үзэн ядагч), “*transphobic*” (хүйсээ солиулсан хүнийг эсэргүүцэгч) гэх мэт ёс суртахууны сөрөг талд шошголох нь түгээмэл байдаг. Энэ мэт шошго нь зүгээр ч нэг үг, хэллэг биш харин нийгмийн хяналтын механизм бөгөөд тухайн хувь хүн, бүлгийг нийтийн орон зайгаас шахах, эсвэл ёс суртахууны хувьд “дорд” байр сууринд оруулах символик шийтгэлийн хэлбэр юм. Бурдьюгийн онолоор бол энэ нь соёлын капиталын хуваарилалтыг удирдаж, “прогрессив” үнэт зүйлсийг дагагчид нийгмийн нэр хүнд, эерэг капитал олж авдаг бол, өөр байр суурьтай хүмүүс “хоцрогдсон”, “алагчилсан, ялгаварласан” гэх статустай болдог (Bourdieu, 1991). Үүний үр дүнд Монголын нийгэмд зөвшөөрөгдсөн “үнэн”-ий хүрээнээс гадуур байр суурь илэрхийлэх орон зай хумигдаж, бодит үзэл санааны өрсөлдөөн, олон талт мэтгэлцээн хумигдаж байна. Энэ нь зөвхөн үзэл суртлын төдийгүй, соёлын болон институтын түвшний эрх мэдлийн дахин хуваарилалтыг хийж буй үзэгдэл юм.

Хоёр. Нийгэм болон аюулгүй байдалд үзүүлэх прогрессив либерализмын нөлөө, үр дагавар

Прогрессив либерализмын суурь шинж болох хэт индивидуалист хандлага нь нийгмийн гишүүдийг нэгтгэдэг үнэт зүйлсийн эсрэг чиглэж, хувь хүний эрх, сонголтыг бүхнээс дээгүүр тавих замаар нийтлэг хэм хэмжээ, хамтын ухамсрын суурийг ганхуулдаг бөгөөд энэ хандлагын хамгийн тод илрэл нь хүйс, бэлгийн чиг хандлага, арьстан, үндэстний асуудлыг улс төр, нийгмийн төвд байршуулах юм. Үзэл суртлын түвшинд энэ нь “тэгш эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх” нэрийн дор бүх төрлийн ялгарал, ялгаатай байдлыг устгахыг эрмэлзэх бөгөөд “хүйсгүй, үндэстэнгүй” глобал нийгмийг бий болгох зорилго бүхий хэмээн үзэх үндэстэй юм.

Социологийн сонгодог онолд нийгэм нь нийтлэг үнэт зүйлс, хэм хэмжээний хэлхээсээс тогтдог бөгөөд хамтын оршихуйн зайлшгүй нөхцөл, тогтвортой байдлын тулгуур болдог. Францын социологич Эмил Дюркгейм “социал факт” (social fact) ойлголтоор нийгмийн бүтэц, соёлын хэм хэмжээ, үнэт зүйлсийг бие хүнээс ангид бөгөөд бие хүнийг чиглүүлдэг бодит хүчин зүйлс гэж үзсэн (Ritzer, 2007, pp. 4414-4416). Дюркгейм социал фактыг материаллаг (хууль, боловсролын систем) болон материаллаг бус (ёс суртахуун, үнэт зүйлс) хэлбэрт хуваан авч үзсэн. Ялангуяа хамтын ухамсар (collective conscience) буюу аливаа нийгмийн хамтын итгэл үнэмшлийн тогтолцоог нийгмийн тогтвортой байдлын үндэс гэж үзсэн байдаг (Ritzer & Stepnisky, 2018, pp. 132-134).

Үүнтэй холбогдуулан энэхүү өгүүллийн хүрээнд шүүмжлэлт дискурс шинжилгээний (CDA) арга зүйг ашигласан бөгөөд хэлний хэрэглээ, үзэл суртал, эрх

мэдлийн бүтэц хэрхэн нийгмийн бодит байдлыг бүтээж буйг илрүүлэхэд чиглэсэн. Үүнд дээр дурдсан асуудлаар иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, дискурсуудыг шинжилж, тэдгээр нь үндэсний ижилсэл, хамтын ухамсарт ямар байдлаар нөлөө үзүүлж буйг тодорхойлох боломжтой болгосон.

Норман Фэйрклофийн боловсруулсан CDA-ийн үндсэн ойлголт нь хэл, үзэл суртал, эрх мэдлийн гурван харилцаанд тулгуурладаг. Шүүмжлэлт дискурс шинжилгээний арга зүйг үндэслэгч Норман Фэйрклоф үзэхдээ хэлний хэрэглээ нь бие хүний үзэл бодол, хандлагын далд тусгалыг онцолсон байдаг бөгөөд хүмүүс бичгээр болон аман байдлаар харилцах үедээ өөрийн үзэл суртал, итгэл үнэмшлийн илрэл, ул мөрийг зайлшгүй үлдээдэг гэжээ (Fairclough, 1992, pp. 12-15).

Энэхүү өгүүллийг хэт урт, нуршуу болохоос сэргийлэн онолын нарийвчилсан загварыг бүрэн тайлбарлахаас зайлсхийж, харин Монголын нөхцөлд текст, дискурс, нийгэм-түүхийн орчин хэрхэн огтлолцож байгааг илрүүлэхэд төвлөрлөө.

Шинжилгээнд зарим төрийн бус байгууллагыг тодорхой шалгуураар сонгосон бөгөөд Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 6000 гаруй ТББ-аас 36 нь залуучуудтай хамтран ажиллаж буйг тогтоов. Үүнд дор хаяж таван жил идэвхтэй үйл ажиллагаа явуулсан, “феминизм ба эмэгтэйчүүдийн эрх”, “жендерийн тэгш байдал”, “ЛГБТК+ эрх”, “олон соёлт байдал”, “цаг уурын өөрчлөлт” зэрэг “прогрессив” чиглэлийн хоёр ба түүнээс дээш асуудлыг хамарсан долоон байгууллагыг сонгож авсан. Тэдгээрийн албан ёсны цахим хуудас, мэдэгдэл, нийтэд нээлттэй хэвлэмэл болон цахим материалуудаас эх сурвалжуудыг цуглуулж, шинжилгээний үндсэн суурь болгосон. Мөн тухайн чиглэлээр олон жил ажилласан долоон мэргэжилтэнтэй хагас бүтэцчилсэн ярилцлага (Semi-structured interview)¹ хийж, тэдний туршлага, байр суурийг тодруулсан юм.

Ёс зүйн хувьд тус шинжилгээнд зөвхөн нийтэд нээлттэй эх сурвалж ашигласан тул хувь хүний нууц, хувийн мэдээлэлд нэвтэрсэн зөрчлийн эрсдэл нэн бага. Харин ярилцлагад оролцогчдоод судалгааны зорилго, ач холбогдлыг бүрэн тайлбарлаж, мэдээлсэн ба зөвшөөрөл авч, нэрээ нууцлах эсэхийг оролцогчдоор шийдэх боломжоор хангаж ажилласан.

Шинжилгээний үр дүнгээс харахад Монголын иргэний нийгмийн зарим байгууллага залуучууд руу чиглэсэн үйл ажиллагаандаа либерал-прогрессив үзэл суртлыг нутагшуулах хоёр үндсэн стратеги хэрэглэж байна. Үүнд:

- *Нэгдүгээрт*, либерал үнэт зүйлсийг Монголын нүүдлийн соёлтой нийцүүлэн харуулах,
- *Хоёрдугаарт* уламжлалт үнэт зүйлсийг хоцрогдсон, хөгжилд саад болж буй мэтээр дүрслэх нь нийтлэг байна.

Иргэний нийгмийн зарим төлөөлөгч либерал-прогрессив үнэт зүйлсийг

¹ Урьдчилсан бэлтгэсэн цөөн асуултын хүрээнд асууж дэлгэрүүлэн нээлттэй хийсэн ярилцлага

“гадаадын” бус Монгол хэл, соёлын хүрээнд ойлгож болохыг онцлохын сацуу, хүйсийн олон янз байдал болон ЛГБТК+ чиг хандлага нь шинэ үзэгдэл биш Монголын эртний шүтлэг болох бөө мөргөлийн хүрээнд оршиж байсан тухай дурдсан юм. Түүнчлэн Монгол хэлний хэрэглээний “манин,” “хөөцөгнөх” зэрэг үгсийг жишээ болгон авч монгол соёлд бэлгийн олон янз байдал оршиж байсны нотолгоо гэж үзэх боломжтойг ч онцолсон юм.

ТББ-аас өгсөн нэг өнцөг нь урлаг, уран сайхныг ашиглан өөрсдийн үзэл санааг илэрхийлэх байв. Жишээ нь нэг оролцогч “Лесбиан Монгол, Гей Монгол, Транс Монгол” сэдэвтэй үзэсгэлэнгийн санаачилгыг тайлбарлаж, энэ нь нийтэд “бид ч мөн адил Монгол хүн” гэсэн мессеж өгөхийн зорьжээ. Мөн “цөөнх” гэсэн шошго нь тэднийг өөрийгөө байнга тайлбарлахад хүргэдэг тул ийм шошгожуулалтаас зайлсхийхийг хүсэж буйгаа ч давхар илэрхийлж байсан юм. Бас нэг ТББ-ын төлөөлөл Монголын уламжлалт үнэт зүйлс, хэвшмэл ойлголтыг өнөөгийн нийгэмд тохирохгүй, хоцрогдсон гэх байр суурийг илэрхийлж, “XXI зуун болчихоод байхад яагаад эмэгтэй Ерөнхийлөгч, Ерөнхий сайд алга байна вэ?” хэмээн асууж, уламжлалт хүйсийн үүргийг шүүмжилж байсан юм. Түүнчлэн, уламжлалт баяр, ёслолын үеэр эмэгтэйчүүдийн гэрийн ажил, ачаалал давамгай байгаа нь эмэгтэйчүүдийн тэгш бус нөхцөл одоо ч оршин буйг онцлов.

Эдгээр нь харьцангуй зөөлөн, дундаж байр суурийг илэрхийлж байгаа бөгөөд үүнтэй зэрэгцэн өдөр тутмын харилцаа, олон нийтийн сүлжээнд илүү радикал өнгө аястай прогрессив дискурс дэлгэрч байгааг энд дурдах хэрэгтэй. Тухайлбал: Эрэгтэйчүүдийг “дарлагч” хэмээн үзэж, эр хүйсийг нийгмийн бүх асуудлын уг сурвалж мэтээр ойлгох, сурталчлах, улмаар эрчүүдийг үзэн ядах хандлага түгээмэл байдаг. Мөн “Монгол үндэстэн гэж байхгүй, хүн л бол хүн,” гэхчлэн үндэсний ижилсэл, хэл соёлын ач холбогдлыг бүдгэрүүлэх эсвэл монголчуудын түүх, хэл, соёлыг “бүдүүлэг” ангилалд оруулж, хүн төрөлхтний түүхэнд оруулсан хувь нэмрийг үгүйсгэх, үндэсний ухамсар, эх оронч үзлийг фашизмтай адилтган харах хандлага ажиглагдаж байна. Дээрх дискурсууд манай нийгэмд, залуучуудын оюун санаанд идэвхтэй оршиж байгааг дурдах нь зүйтэй. Энэ нь үндэсний хамтын ухамсар, нийгмийн тогтсон хэм хэмжээг сорьж, шинэ үзэл санааг залуусын ухамсарт шингээх, шинэ ижилсэл, ялгарал бүтээх оролдлого гэж дүгнэж болохоор байна.

Түүнчлэн гадаад санхүүжилт, олон улсын байгууллагуудын нөлөө давамгайлж байгаа нь нийгмийн аюулгүй байдалд тэр дундаа Барри Бузаны тодорхойлсон “societal security”-ийн хэмжээнд шууд хамааралтай стратегийн эрсдэл үүсгэж байна (Buzan, Wæver, & De Wilde, 1998) Түүний онолоор нийгмийн аюулгүй байдал гэдэг нь тухайн нийгэм өөрийн ижилсэл ба ялгарал, хэл, соёл, түүхэн өв, уламжлалт үнэт зүйлсээ хадгалан орших тухай бөгөөд энэ нь дараах тохиолдолд аюул заналд өртдөг. Тухайлбал:

- *Шилжилт хөдөлгөөн (цагаачлал)*. Хүн амын бүтцэд өөрчлөлт оруулснаар олонхын хэл, соёл, үнэт зүйлс бүдгэрэх;
- *Хэвтээ өрсөлдөөн*. Гадаадын соёл, хэл, үнэт зүйлс дотоодынхыг давамгайлж, уламжлалт соёлын хэв маяг алдагдах;
- *Босоо өрсөлдөөн*. Иргэд өөрийгөө тухайн үндэстэн, соёлын нэг хэсэг гэж үзэхээ болих, илүү өргөн (глобал) эсвэл эсрэгээрээ хэт нарийн хүрээний бүлгийн харьяаллаар өөрийгөө тодорхойлох үзэл давамгайлах (Buzan, Wæver, & De Wilde, 1998, т. 120-121).

Прогрессив либерализмын үзэл суртал дээрх шалгуурт нийцэх хэд хэдэн шинжээр нийцэж байна.

Нэгдүгээрт, олон соёлт байдал (multiculturalism) нь хилийн нээлттэй байдал, чөлөөтэй шилжилт хөдөлгөөн зэргийг идэвхтэй дэмждэг. Энэ нь урт хугацаандаа Монголын хүн амын бүтэц, хэл, соёл, үндэсний онцлогийг бүдгэрүүлэх эрсдэлтэй.

Хоёрдугаарт, барууны глобал үнэт зүйлийг “дэлхийн нийтлэг үнэт зүйл” болгон тулган хүлээлгэх нь Монголын уламжлалт ёс суртахуун, хамтын ухамсрыг хоцрогдсон, ач холбогдолгүй мэт ойлгуулах замаар соёлын давамгайлал буюу хэвтээ өрсөлдөөнийг бий болгоно.

Гуравдугаарт, цөөнх бүлгийн эрхийг хамгаалах нэрийн дор нийгмийн ан цавыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь босоо өрсөлдөөний шинж чанарыг агуулж байна. Иймд прогрессив либерализм нь үндэсний хамтын ухамсар, соёлын дархлаа, нийгмийн нэгдмэл байдлыг системтэйгээр сулруулж, Монгол Улсын нийгмийн тогтвортой байдал, соёл иргэншлийн аюулгүй байдалд заналхийлэх хүчин зүйл гэж үзэх үндэстэй юм.

Энэ нөхцөл байдлыг Монголын нэрт социологичид анхааруулж ирсэн байдаг. Тухайлбал: Д.Ганхуяг нь “уламжлал ба эвдэн бусниулагч” үнэт зүйлсийг тодорхойлж, аминч үзэл эх оронч үзлийг үгүйсгэх, уламжлалт гэр бүл, ёс суртахууны тогтолцоог задлах зэрэг нь нийгмийн тогтвортой байдалд заналхийлнэ гэж үзсэн байдаг (Ганхуяг, 2024). Мөн Х.Гүндсамбуу 2003 онд бичсэн өгүүлэлдээ “Гэр бүл салалт, уламжлалт зан байдлын доройтол нэмэгдэж, гаднын “гаж” соёлын элементүүд давамгайлах болсон нь Монголын гэр бүлийн институтэд хүчтэй нөлөөлж байгаа”-г анхааруулж байжээ (Гүндсамбуу, 2003, р. 46) Түүний хэлсэнчлэн даяаршлыг дан эерэг талаас харах нь өрөөсгөл бөгөөд Монгол Улс соёлын довтолгоог сөрөн тэсвэрлэх чадвартай байх ёстой юм.

Дүгнэлт

Энэхүү өгүүллээр либерал-прогрессив үзэл суртал нь хүний эрх, жендерийн тэгш байдал, олон янз байдал гэх мэт уриа, лоозонгийн дор Монголын хамтын ухамсар, соёлын залгамж, уламжлалт институтүүдийн суурийг алгуурхан сулруулж буйг тайлбарлалаа. Иргэний нийгмийн байгууллагууд (зөвхөн нэг суваг нь), ялангуяа

залуучууд руу чиглэсэн хөтөлбөрүүдээр дамжин “шинэ” дискурс нэвтэрснээр ёс суртахууны тогтолцоо, хамтын ухамсар, үндэсний ижилслийг өөрчлөх, улмаар Монгол Улсын батлан хамгаалах бодлогын тулгуур болсон нийгмийн эв нэгдэл, оюун санааны нэгдмэл байдлыг доройтуулах эрсдэл илэрхий болж байна. Социологийн үүднээс тайлбарлавал энэ нь Дюркгеймийн тодорхойлсон хамтын ухамсар, Бурдьегийн тайлбарласан символик эрх мэдэл, Бузаны тодорхойлсон нийгмийн аюулгүй байдлыг доройтуулах үйл явц гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл: Монгол Улс барууны загварыг шууд хуулбарлах бус өөрийн уламжлал, түүхэн туршлага, орчин үеийн мэдлэгийг хослуулан үндэсний онцлогт нийцсэн “Үндэсний үзлийн систем”-ийг бий болгох ёстой юм.

Хэрэв ийм цогц систем үүсэж чадахгүй бол либерал-прогрессив үнэт зүйлсийн давлагаа үнэхээр Монголын эрх ашигт нийцэх үү? Үндэсний ижилсэл, хамтын ухамсар суларсан нөхцөлд батлан хамгаалах бодлого аливаа аюул заналын үед нэгтгэн дайчлах чадвараа хадгалж чадах уу? Хамгийн гол нь хамтын ухамсар эвдэгдэж, суларсан нөхцөлд Монгол Улсын аюулгүй байдал хэрхэн баталгаажих вэ?

Эх сурвалжийн жагсаалт

- Berger, J., & Luckmann, T. (1966). The social construction of reality: . *A treatise in the sociology of knowledge* (хуудсд. 13-15).-Д New York, NY: Open Road Media.
- Bourdieu, P. (1991). Language and symbolic power. *Language and symbolic power* (хуудсд. 170-172).-Д Cambridge, MA: Harvard University Press.
- Buzan, B., Wæver, O., & De Wilde, J. (1998). *Security: A new framework for analysis*.
- Deneen, P. J. (2018). *Why liberalism failed*. New Haven, CT: Yale University Press.
- Fairclough, N. (1992). Discourse and social change. In *Discourse and social change* (pp. 12-15). Cambridge: Polity Press.
- Foucault, M. (1972). The archaeology of knowledge. T. a. knowledge.-Д London, England:: Routledge.
- Hak, G. (2021). Liberal progressivism. In *Liberal progressivism* (p. 3). London, England: Routledge.
- Janks, H. (1997). Critical discourse analysis as a research tool. *Studies in the Cultural Politics of Education* (хуудсд. 18(3), 329–342).-Д Discourse: Studies in the Cultural Politics of Education, 18(3), 329–342. <https://doi.org/10.1080/0159630970180302>. doi:<https://doi.org/10.1080/0159630970180302>
- Mearsheimer, J. J. (2018). The great delusion: . *Liberal dreams and international realities*. (хууд. 83; 158).-Д New Haven, CT: Yale University Press.
- Parton, N. (2008). Reviewed work: The social construction of reality: A treatise in the sociology of knowledge by Peter L. Berger & Thomas Luckmann. *The British Journal of Social Work*, 2008(4), 823–825. doi:<https://doi.org/10.1093/bjsw/bcn074>
- Ritze, G., & Stepnisky, J. (2018). *Sociological theory*. (1. ed, Ed.) London England.
- Ritzer, G. (2007). *The Blackwell encyclopedia of Sociolog*. Malden, MA: Blackwell.

Ганхуяг. (2024 оны Наймдугаар 18). Уламжлалт ба эвдэн бусниулагч үнэт зүйлсийн тухайд. Судлаач Ганаа [Sudlaach Ganaa blog]: <https://gankhuyag.com/2024/08/18/%d1%83%d0%bb%d0%b0%d0%bc%d0%b6%d0%bb%d0%b0%d0%bb%d1%82-%d0%b1%d0%b0-%d1%8d%d0%b2%d0%b4%d1%8d%d0%bd-%d0%b1%d1%83%d1%81%d0%bd%d0%b8%-d1%83%d0%bb%d0%b0%d0%b3%d1%87-%d2%af%d0%bd%d1%8d%d1%82-%d0%b7%d2%af/-ээс> Гаргасан

Гүндсамбуу, Х. (2003). Айл гэрийн социологийн асуудлууд. *Социологи* (3), 46-52.

Монгол Улсын Их Хурал. (2022). *Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс*.

Монгол Улсын Их Хурал. (2022). *Орон нутгийн хамгаалалтын тухай*. legalinfo.mn.

Social Dimensions of Defense Policy: Tensions between National Consciousness and Liberal Democratic Values

Bilguun Terbish

Master of Arts, Researcher, bilguun@mids.gov.mn

Policy Analysis Centre,

Defense Research Institute of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Abstract

This article examines the influence of progressive liberal discourse emerging in Mongolian society, seeking to identify the challenges it poses to national identity, collective consciousness, and traditional values. The analysis brings together classical and contemporary sociological theories with critiques from political realism, drawing in particular on Durkheim's concept of collective conscience, Foucault's concept of discourse, Bourdieu's theory of symbolic power, and Buzan's notion of societal security. Methodologically, the analysis relies on Norman Fairclough's critical discourse analysis and incorporates publicly available documents, online sources, and interview data from civil society organizations engaged in youth-oriented activities in Mongolia. Within this framework, the study identifies challenges related to social cohesion, cultural continuity, national security, and defense policy. It demonstrates that attempts to localize the values of progressive liberalism come into fundamental conflict with traditional values, gradually weakening social trust, collective consciousness, and the resilience of national identity.

Keywords: National identity, Collective consciousness, Defense policy, Liberal-progressivism, Symbolic power

Received: September 8, 2025 | Accepted: September 15, 2025 | Published online: October 13, 2025



© The Author(s) 2025

<http://creativecommons.org/licenses/by/4.0/>.